

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай

Нэг.Нийтлэг үндэслэл

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр “Монголбанкны үндсэн зорилтыг үнийн тогтвортой байдал болгон тодорхойлох буюу инфляцын нам, тогтвортой түвшинд чиглүүлэх замаар мөнгөний бодлогын тууштай байдлыг хангах, төсвийн бодлого мөнгөний бодлоготой уялдах эрх зүйн орчныг бүрдүүлэх, Төв банкны төсвийн шинжтэй үйл ажиллагааг хориглох, мөн Монголбанкны хуримтлагдсан алдагдлаас үүдсэн өөрийн хөрөнгийн дутагдлыг нөхөх эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох” харилцааг зохицуулна.

Хуулийн төслийг боловсруулахдаа хууль санаачлагч нь Монголбанкны алдагдлын бүтэц, санхүүгийн стресс төстийн дүн, Төв банкны бие даасан байдлын олон улсын үнэлгээ, гадаад улсын ижил төстэй зохицуулалтыг харьцуулан судалж, одоогийн эрх зүйн орчинд үүсээд буй бодит хүндрэл, эрсдэлийг арилгах шаардлагыг үндэслэл болгосон болно.

Хуулийн төслийг Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэрээр боловсруулж дараах зохицуулалтыг тусгасан. Үүнд:

- Монголбанкны үндсэн зорилтыг үнийн тогтвортой байдал буюу хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн инфляцын нам дор тогтвортой түвшнийг хангах болгон тодорхойлсон.
- Монголбанк мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг жил бүрийн 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлаас төрийн мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл батлахдаа инфляцын зорилт, үүнтэй уялдуулсан төсвийн зардлыг хязгаарлах төсвийн тусгай шаардлага, төв банкны өөрийн хөрөнгийн дутагдлыг нөхөх Засгийн газрын үнэт цаасны хэмжээг зааж өгөрөөр тусгав.
- Төв банк /Монголбанк/-ны тухай хуулиар төсвийн шинжтэй үйл ажиллагааг бүрэн хориглохоор төсөлд тусгасан.
- Төв банкны өөрийн хөрөнгийг Засгийн газраас тусгай үнэт цаас гаргаж, Монголбанканд эзэмшүүлэх замаар сэргээх үндэслэл, журмыг нарийвчлан шинэчлэн тогтоосон болно.

Хоёр.Хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлтийг төслийн зүйл тус бүрээр авч үзвэл:

1.Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн тухайд:

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд “Монголбанкны үндсэн зорилтыг үндэсний мөнгөн тэмдэгт–төгрөгийн тогтвортой байдлыг хангах” хэмээн тодорхойлсон нь инфляцын нам дор тогтвортой түвшин-үнийн тогтвортой байдал, эсхүл төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн тогтвортой байдал буюу гадаад үнэ гэх байдлаар хууль хэрэглээ, цаашлаад бодлого

тууштай хэрэгжихгүй байх асуудал үүсгэж байна. Мөн Улсын Их Хурлаас төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл батлахдаа үнийн тогтвортой байдлын зорилтын хамт макро эдийн засгийн тогтвортой байдал, банк санхүүгийн салбарын тогтвортой байдал, санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, институцийн хөгжлийг дэмжих зэрэг олон зорилтыг давхар тусгасаар иржээ. Эдгээр зорилтын хоорондын эрэмбэ, үндсэн болон дэд зорилтын ялгааг тодорхой тогтоогоогүйгээс үнийн тогтвортой байдал Монголбанкны үндсэн зорилт гэх ойлголт бүрэн тогтоогүй, ийнхүү эрэмбэлэн хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт хангалтгүй байсан.

Иймд, Монголбанкны үндсэн зорилтыг “үнийн тогтвортой байдлыг хангах” хэмээн хуульчлан тодорхойлох нь Төв банк өөрийн үндсэн зорилт болох инфляцын нам дор тогтвортой түвшинийг хангахад нийцэхгүй чиглэл, үүрэг, зөвлөмжийг биелүүлэхээс зайлсхийх, үндсэн зорилтоос урьтаж бусад зорилтыг биелүүлэх нөхцөлийг хязгаарлах эрх зүйн баталгааг бүрдүүлэх юм.

Монгол Улс 1991 онд нэгдэн орсон Олон улсын валютын сангийн Үүсгэн байгуулах гэрээний 4 дүгээр зүйлийн 4.1.1-д зааснаар гишүүн улс орнууд нь үнийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн эдийн засаг, санхүүгийн бодлого хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг.

Инфляцыг онилсон мөнгөний бодлогыг Европын холбоо, Канад, Шинэ Зеланд, Солонгос зэрэг дийлэнх улс орон хэрэгжүүлж, Төв банкны зорилтыг үнийн тогтвортой байдал гэж хуульчилсан нь инфляцыг урт хугацаанд нам түвшинд барихад эерэг нөлөө үзүүлсэн сайн туршлага болохыг харуулдаг.

2.Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн тухайд:

Хуулийн төслийн 10 дугаар зүйлд Монголбанк төрийн мөнгөний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбогдсон эрх хэмжээ болон мөнгөний бодлогын талаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх баримт бичгийн агуулгыг тодорхой болгож, мөнгөний бодлого болон төсвийн бодлогын уялдааг бэхжүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг тусгасан болно.

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд Монголбанк төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй гэж заасан боловч мөнгөний бодлогын талаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх баримт бичигт ямар бодлогын үзүүлэлтүүдийг тусгах, мөн тэдгээр нь макро эдийн засгийн бодлогын хүрээнд хэрхэн уялдах талаар тодорхой зохицуулалт хангалттай бус байсан. Үүний улмаас мөнгөний бодлогын зорилт, төсвийн бодлогын чиглэл, макро эдийн засгийн бодлогын хүрээ хоорондын уялдаа зарим тохиолдолд сулрах, төсвийн бодлогын тэлэлт нь мөнгөний бодлогын зорилтод сөргөөр нөлөөлөх, улмаар Төв банкны бодлогын үр нөлөөг бууруулсаар иржээ.

Иймд мөнгөний бодлогын бодит хэрэгжилтийг дунд хугацааны макро эдийн засгийн хүрээнд тодорхойлж, Төв банкны бодлого болон төсвийн бодлогын харилцан уялдааг илүү тодорхой болгох зорилгоор Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийг шинэчлэн найруулж, дараах зохицуулалтыг тусгасан.

Нэгдүгээрт, Монголбанк жил бүр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн төслийн агуулгыг тодорхой болгосон. Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монголбанк төрөөс дараагийн жилд баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, жил бүрийн 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бөгөөд уг баримт бичигт тодорхой үзүүлэлтүүдийг заавал тусгахаар зохицуулсан.

Энэхүү зохицуулалтын хүрээнд тайлант оны мөнгөний бодлогын хэрэгжилтийн явц, санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийн талаарх дүн шинжилгээг тусгах шаардлагыг тогтоосон. Энэ нь мөнгөний бодлогын хэрэгжилтийн үр дүнг олон нийт болон хууль тогтоох байгууллагад ил тод тайлагнах, бодлогын шийдвэрийн үндэслэлийг тайлбарлах, бодлогын хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

Хоёрдугаарт, Монголбанкнаас дараагийн гурван жилд баримтлах инфляцын зорилтот түвшин, инфляцын төсөөлөл болон санхүүгийн зах зээлд нөлөөлж болох хүчин зүйлсийн талаарх дунд хугацааны макро эдийн засгийн төсөөллийг мөнгөний бодлогын баримт бичигт тусгахаар заасан. Энэхүү зохицуулалт нь инфляцыг онилох мөнгөний бодлогын тогтолцоонд нийцэж байгаа бөгөөд бодлогын урьдчилан харагдах байдлыг сайжруулах, зах зээл болон олон нийтийн инфляцын хүлээлтийг тогтвортой байлгах чухал ач холбогдолтой.

Гуравдугаарт, Мөнгөний бодлогын зорилттой нийцсэн төсвийн бодлогын хүрээг тодорхойлох зохицуулалтыг тусгасан. Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт улсын нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хязгаарыг нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиар илэрхийлэн мөнгөний бодлогын баримт бичигт тусгахаар зохицуулсан.

Энэхүү зохицуулалт нь төсвийн бодлогын хэт тэлэлтээс үүдэлтэй макро эдийн засгийн тэнцвэргүй байдлыг бууруулах, мөнгөний бодлого болон төсвийн бодлогын уялдааг хангах, улмаар төсвийн давамгайллаас үүдэлтэй эрсдэлийг багасгах зорилготой юм. Олон улсын туршлагаас харахад төсвийн бодлогын тэлэлт нь инфляцын дарамтыг нэмэгдүүлэх, мөнгөний бодлогын хэрэгжилтийг хүндрүүлэх, Төв банкны бодлогын үр нөлөөг сулруулж төв банкнийг алдагдалтай болгох шалтгаан нөхцөл болдог тул мөнгөний болон төсвийн бодлогын уялдааг эрх зүйн түвшинд тодорхой болгох нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чухал арга хэрэгсэл болдог.

Дөрөвдүгээрт, Төв банкны санхүүгийн бие даасан байдлыг хангах зорилгоор Монголбанкны өөрийн хөрөнгийн дутагдлыг нөхөх зориулалттай Засгийн газрын тусгай үнэт цаасны хэмжээг мөнгөний бодлогын үндсэн чиглэлд тусгах зохицуулалтыг оруулсан.

Монголбанкны санхүүгийн тайлангаар өөрийн хөрөнгө сөрөг утгатай болсон тохиолдолд Төв банкны алдагдлыг нөхөх асуудлыг тодорхой бодлогын хүрээнд шийдвэрлэх шаардлага үүсээд байна. Иймд Төв банкны өөрийн хөрөнгийн дутагдлыг нөхөж сэргээх зорилгоор гаргах Засгийн газрын туснай үнэт цаасны хэмжээг мөнгөний бодлогын баримт бичигт тусгаж, Улсын Их Хурал батлах зохицуулалтыг тусгаснаар Төв банкны санхүүгийн бие даасан байдлыг сэргээх эрх зүйн шууд хэрэгжих боломжтой, үзэмжид бус дүрэмд суурилсан зохицуулалт бүрдэнэ.

Түүнчлэн хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Улсын Их Хурал мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг батлахдаа инфляцын зорилтот түвшин, төсвийн зарлагын хязгаар, Төв банкны өөрийн хөрөнгийн дутагдлыг нөхөх Засгийн газрын тусгай үнэт цаасны хэмжээг хамтад нь батлахаар зохицуулсан. Энэ нь мөнгөний бодлого, төсвийн бодлого болон Төв банкны санхүүгийн тогтвортой байдлыг хангах бодлогын хүрээг нэгтгэн тодорхойлох ач холбогдолтой.

Мөн хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт дээр дурдсан үзүүлэлтүүдийг бусад хуулийн төслийг хэлэлцэх, батлахдаа дагалдах байдлаар өөрчлөхийг хориглосон зохицуулалтыг тусгасан. Энэ нь мөнгөний бодлогын зорилт болон макро эдийн засгийн бодлогын хүрээг богино хугацааны шийдвэрээр өөрчлөхөөс сэргийлэх, бодлогын тууштай байдлыг хангах, Төв банкны бодлогын итгэлцлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Ийнхүү хуулийн төслийн 10 дугаар зүйлд тусгасан зохицуулалт нь Монголбанкны мөнгөний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх эрх хэмжээг тодорхой болгож, мөнгөний бодлогын баримт бичгийн агуулгыг олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлохын зэрэгцээ мөнгөний бодлого, төсвийн бодлогын уялдааг бэхжүүлэх, Төв банкны санхүүгийн бие даасан байдлыг сэргээх эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэж байна.

3.Хуулийн төслийн 38¹ дүгээр зүйлийн тухайд:

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулиар Монголбанкны алдагдалыг нөхөх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэхээр заасан ч өнгөрсөн хугацаанд энэ заалт хэрэгжээгүй. 2025 оны эцсийн байдлаар Монголбанкны хуримтлагдсан алдагдал -6.9 их наяд төгрөг, өөрийн хөрөнгийн дутагдал -4.8 их наяд төгрөгт хүрсэн боловч уг дутагдлыг нөхөх Засгийн газрын үүрэг, хугацаа, арга механизмыг хуульд тодорхой тусгагдаагүй нь уг зохицуулалт хэрэгжээгүй гол шалтгаан болсон гэж үзэж байна.

Өөрийн хөрөнгийн дутагдлыг Засгийн газрын зах зээлийн нөхцөлтэй, хугацаатай, хүүтэй үнэт цаасаар нөхөж сэргээх журмыг хуульчилж, үүнийг мөнгөний бодлогын баримт бичиг болон улсын төсөвтэй уялдуулан хэрэгжүүлэхээр хуулийн төсөлл тусгасан. Ингэснээр Төв банкны санхүүгийн бие даасан байдал бодитоор хангагдана.

Төв банкны алдагдал мөнгөний бодлогын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж, цаашлаад инфляцыг хяналтаас алдах, санхүүгийн бие даасан байдлаа алдахад хүргэх хор уршигтай тул алдагдлыг зохих ёсоор нөхөх шаардлагатай гэдгийг олон орны хууль тогтоомжид төрийн институцийн үүрэг болгон баталгаажуулсан байдаг. Төв банк их хэмжээний алдагдал хүлээсэн тохиолдолд Засгийн газраас дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг гадаад улсууд хуульд тусгаж, төв банкны бодлогын хараат бус байдлыг хамгаалдаг сайн туршлага түгээмэл байна.

4.Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 8 дахь заалт нэмэх тухайд:

Төв банкны санхүүгийн эх үүсвэрийг бодлогын бус, төсвийн шинжтэй зорилгоор ашиглах, мөнгөний бодлогын хэрэгсэлд төсвийн чиг үүрэг давхардах байдал сүүлийн жилүүдэд давтагдах

болсон. Төсвийн шинжтэй үйл ажиллагааг төв банкнаас санхүүжүүлэх явдал нь мөнгөний бодлогын хараат бус байдалд сөргөөр нөлөөлөхөөс гадна төв банкны санхүүгийн алдагдлыг нэмэгдүүлэх суурь шалтгаан болдог тул уг асуудлыг хууль зүйн түвшинд бүрэн хориглох шаардлага үүссэн.

Хуулийн төслөөр төв банкны хориглох үйл ажиллагаанд Монголбанкнаас төсвийн шинжтэй аливаа төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг санхүүжүүлэхийг хориглох заалт тусгаснаар Төв банкны үйл ажиллагаа зөвхөн мөнгөний бодлогын зорилт, чиг үүрэгт төвлөрч, төсвийн бодлогоос институцийн хувьд зааглагдах эрх зүйн баталгаа бүрдэнэ.

Олон улсын практикт Төв банк төсвийн шинжтэй үйл ажиллагааг санхүүжүүлэхийг хатуу хориглодог зохицуулалт түгээмэл байдаг. Тухайлбал, Европын төв банк болон Канад, Чили зэрэг улсын төв банкны хууль тогтоомжид төсвийн чиг үүргийг төв банкнаас ангид байлгах тодорхой заалтууд тусгагдсан нь төв банкны хараат бус байдлыг хамгаалах үндсэн хэрэгсэл болдог.

5.Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "...төрөөс үүсгэн байгуулсан..." гэсний дараа "нийтийн эрх зүйн" гэж, 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад "хуульд" гэсний өмнө "энэ" гэж нэмэх зохицуулалтын тухайд:

Монголбанкны эрх зүйн байдал, хуулийн этгээдийн ангиллыг тодорхой зохицуулаагүй нь Монголбанкны бүрэн эрхийн хүрээ, хариуцлагын зааг, түүнчлэн бусад төрийн байгууллагатай харилцах харилцаанд тодорхой бус байдал бий болгох нөхцөлийг бүрдүүлсэн. Иймд Монголбанкийг төрөөс үүсгэн байгуулсан нийтийн эрх зүйн хуулийн этгээд хэмээн хуульд тодорхой, хоёрдмол утгагүйгээр тусгаж, хуулийн заалтуудын хэрэглээг нэг мөр ойлгомжтой болгох замаар эрх зүйн тодорхой байдал, институцийн тогтвортой байдлыг хангана.

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын "хуульд" гэсний өмнө "энэ" гэж нэмж тусгаснаар тухайн хориг, хязгаарлалт нь зөвхөн Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн хүрээнд хамаарахыг тодотгоно.

Олон улсын туршлагад төв банкиг нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэж тодорхойлж, түүний бүрэн эрх, хязгаарлалтыг тусгайлсан хуульд нарийвчлан заах зохицуулалт нийтлэг байдаг. Энэ нь төв банкны институцийн бие даасан байдлыг хамгаалах эрх зүйн үндэс болдог.

6.Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцож буйтай холбогдох тайлбар:

Банкны тухай хуулийн "Банкинд онцгой дэглэм тогтоох" хэсгийг 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар хассан. Энэхүү өөрчлөлт нь банкны салбарын эрх зүйн орчныг шинэчлэх банкны бүтэц зохион байгуулалт болон үйл ажиллагааны зохицуулалтыг боловсронгуй болгох олон улсын стандартад нийцүүлэх зорилготой. Иймд Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т "банкны төлбөрийн чадварт гарсан хүндрэл нь банкны тогтолцоо, төлбөр тооцооны тогтолцооны шинж чанартай эрсдэлийг үүсгэж болзошгүй болсон

гэж үзэж Монголбанк онцгой дэглэм тогтоосон” гэх заалт нь практикт хэрэгжих боломжгүй болсон гэж үзэж Банкны тухай хуульд нийцүүлэн хүчингүй болгохоор хуулийн төсөлд тусгасан.

Олон улсын практикт бодлогын шинэчлэлтэй уялдуулан ач холбогдлоо алдсан, давхардсан зохицуулалтыг хууль тогтоомжоос хасах нь эрх зүйн тодорхой байдлыг хангах нийтлэг аргачлал юм.

Гурав.Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл

Хуулийн төслийг бодитой хэрэгжүүлэх, Монголбанкны өөрийн хөрөнгийн дутагдлыг үе шаттай, төсөвт дарамт үзүүлэхгүйгээр нөхөх зорилгоор Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулсан.

Дагаж мөрдөх журмын тухай хуулиар хуульд заасан хугацаанд өөрийн хөрөнгийн дутагдлыг нөхөх, өөрийн хөрөнгийн дутагдлыг нөхөх Засгийн газрын тусгай үнэт цаасны хугацаа, хүү, жил бүрийн дээд хэмжээг тогтоох, төсөв, өөрийн удирдлагатай уялдуулах зэрэг шилжилтийн болон хэрэгжилтийн нарийвчилсан зохицуулалтыг тусгаснаар Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль бодитоор хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

Дөрөв.Дагалдах хуулийн төслийн талаар

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Төсвийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай, Өөрийн удирдлагын тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах бөгөөд эдгээр хуулийн төсөлд Монголбанкны өөрийн хөрөнгийн дутагдлыг нөхөх Засгийн газрын тусгай үнэт цаас, түүнийг төсөвт тусгах, өөрийн удирдлагатай уялдуулах, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зохицуулалтыг тусгасан болно.

1.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дагуу Монголбанкны өөрийн хөрөнгийн дутагдлыг Засгийн газрын тусгай үнэт цаас гаргах замаар үе шаттайгаар нөхөх эрх зүйн механизмыг бүрдүүлнэ. Гэвч Монголбанкны өөрийн хөрөнгийг нөхөх зорилгоор гаргах Засгийн газрын тусгай үнэт цаас нь төсвийн сахилга бат, өөрийн тогтвортой байдлын шалгуур үзүүлэлтүүдэд хэрхэн тусах талаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тодорхой зохицуулалт байхгүй байгаа нь дээрх механизмыг хэрэгжүүлэхэд эрх зүйн тодорхойгүй байдал хийдэл үүсгээд байна.

Тухайлбал, Монголбанкны өөрийн хөрөнгийн дутагдлыг нөхөх зорилгоор гаргах Засгийн газрын тусгай үнэт цаасны үлдэгдэл болон түүнтэй холбоотой гүйлгээг төсвийн тусгай шаардлага, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын хэмжээг тооцоход оруулах эсэх талаар одоогийн хуульд тодорхой зохицуулалт байхгүй байна. Энэ нь Төв банкны

санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилготой бодлогын арга хэмжээг төсвийн сахилгын шалгуур үзүүлэлтүүдтэй зөрчилдөх нөхцөл үүсгэх эрсдэлтэй. Иймд Монголбанкны өөрийн хөрөнгийн дутагдлыг нөхөх зорилгоор гаргах Засгийн газрын тусгай үнэт цаасны үлдэгдэл, түүнтэй холбоотой гүйлгээг төсвийн тусгай шаардлага болон нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тооцоонд оруулахгүй байх, мөн мөнгөний бодлогын үндсэн чиглэлд туссан үзүүлэлтийг төсвийн бодлогын хүрээнд хангах зохицуулалтыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тусгах шаардлага үүссэн.

Энэхүү хуулийн төслөөр Монголбанкны өөрийн хөрөнгийн дутагдлыг нөхөх зорилгоор гаргах Засгийн газрын тусгай үнэт цаастай холбоотой санхүүгийн гүйлгээг төсвийн сахилга бат, өрийн тогтвортой байдлын шалгуур үзүүлэлтүүдийг зөрчихгүйгээр нийцүүлэх, Төв банкны санхүүгийн тогтвортой байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

2.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын тусгай үнэт цаас гаргах, түүний эрх зүйн зохицуулалтыг Өрийн удирдлагын тухай хуульд тодорхой тусгах шаардлага үүсч байна.

Одоогийн мөрдөж байгаа Өрийн удирдлагын тухай хуульд Монголбанкны өөрийн хөрөнгийн дутагдлыг нөхөх зорилгоор Засгийн газрын тусгай үнэт цаас гаргах, түүнийг өрийн удирдлагын бодлого, өрийн дээд хязгаар, өрийн статистикт хэрхэн тусгах талаар тодорхой зохицуулалт байхгүй, хууль бодитой хэрэгжих боломжгүй хийдэлтэй байна. Иймд Төв банкны санхүүгийн тогтвортой байдлыг хангах бодлогын арга хэмжээг өрийн удирдлагын бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Хуулийн төслийн зорилго нь Монголбанкны өөрийн хөрөнгийн дутагдлыг нөхөх зорилгоор Засгийн газрын тусгай үнэт цаас гаргах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, уг үнэт цаасыг Засгийн газрын өрийн удирдлагын бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх зохицуулалтыг Өрийн удирдлагын тухай хуульд тусгасан.

3.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай төслийн талаар:

Монголбанкны өөрийн хөрөнгийн дутагдлыг нөхөх арга хэмжээ нь Засгийн газрын үнэт цаас гаргах замаар хэрэгжихээр төлөвлөгдөж байгаа бөгөөд уг арга хэмжээг төсвийн төлөвлөлт, төсвийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах шаардлагатай байна. Одоогийн мөрдөж байгаа Төсвийн тухай хуульд Монголбанкны өөрийн хөрөнгийн дутагдлыг нөхөхөд шаардагдах санхүүжилтийн хэмжээ, түүнийг төсвийн төлөвлөлтийн үе шатанд хэрхэн тусгах талаар тодорхой зохицуулалт байхгүй байгаа нь төсвийн бодлого, мөнгөний бодлогын уялдаа холбоог хангахад хүндрэл үүсгэхээр байна.

Иймд Монголбанкны өөрийн хөрөнгийн дутагдлын хэмжээ, түүнийг нөхөхөд шаардагдах Засгийн газрын үнэт цаасны хэмжээ, нөхцөлийг төсвийн бодлогын баримт бичигт тусгах, мөн

мөнгөний бодлогын үндсэн чиглэлд туссан үзүүлэлтийг төсвийн төсөл боловсруулах явцад харгалзан үзэх эрх зүйн зохицуулалтыг Төсвийн тухай хуульд нэмэлтээр оруулсан.

4.Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Монголбанкны өөрийн хөрөнгийн дутагдлыг Засгийн газрын тусгай үнэт цаас гаргах замаар нөхөх эрх зүйн механизмыг бүрдүүлэхээр тусгасан. Энэхүү механизмыг хэрэгжүүлэх хугацаа, нөхцөл, санхүүжилтийн үе шатыг тодорхойлох зорилгоор уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн төслийн зорилго нь Монголбанкны өөрийн хөрөнгийн дутагдлыг үе шаттайгаар нөхөх хугацаа, санхүүжилтийн нөхцөл, хэрэгжүүлэх зарчим болон төсвийн бодлого, өрийн удирдлагын бодлоготой уялдуулах зохицуулалтыг тодорхойлох замаар Төв банкны санхүүгийн тогтвортой байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэхээр зохицуулсан. Тухайлбал, Монголбанкны өөрийн хөрөнгийн дутагдлыг тодорхой хугацаанд үе шаттайгаар нөхөх зохицуулалтыг тогтоож, 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх дутагдлыг Засгийн газар 2031 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн нөхөхөөр тусгалаа. Мөн төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэх зэрэг урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд Монголбанктэй зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын тусгай үнэт цаасны хүүгийн төлбөрийг тодорхой хугацаанд хойшлуулах боломжийг хуульчилсан.

5.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэхүү хуулийн төслийг Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй уялдуулан боловсруулсан бөгөөд гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх, алтны албан ёсны нийлүүлэлтийг дэмжих, валютын зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

Одоогийн мөрдөгдөж буй зохицуулалтаар алт олборлогч этгээдүүдийн алт тушаах, борлуулах харилцаа тодорхой боловч худалдан авах этгээдийг нарийвчлан заагаагүй, мөн татварын ачаалал харьцангуй өндөр байгаа нь алтны албан ёсны нийлүүлэлтийг хязгаарлах, улмаар гадаад валютын урсгалыг төвлөрүүлэх боломжийг сулруулж байна.

Иймд хуулийн төслөөр Монголбанк болон эрх бүхий банкаар дамжуулан алтны албан ёсны худалдан авалтыг төвлөрүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд энэ нь алтны албан бус зах зээлийг бууруулах, валютын урсгалыг албажуулах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Хуулийн төслийг баталж хэрэгжүүлснээр Монголбанкны гадаад валютын албан нөөц нэмэгдэх, алтны албан ёсны нийлүүлэлт өсөх, валютын ханшийн савлагаа буурах, мөнгөний бодлогын үр нөлөө сайжрах, далд эдийн засаг буурах зэрэг макро эдийн засгийн эерэг үр дагавар бий болно.

Энэхүү дэлгэрэнгүй танилцуулга нь хуулийн төслийн агуулга, зорилго, зохицуулалтыг ойлгож хэрэгжүүлэхэд хэрэглэгдэх тайлбар болох боловч Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасны дагуу хуулийн албан ёсны тайлбар биш болно.

---oOo---

